

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 3 ДУГААР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2018.03.23

Сургалт, сурталчилгаа:

Иргэд олон нийтэд газрын харилцааны чиглэлээр болон орон нутагт хийгдэж буй бүтээн байгуулалтын ажлуудын талаар мэдээлэл, зөвлөгөө өгөх зорилгоор аж ахуйн нэгж, албан байгууллагуудад “Мэдээллийн цаг”-аар ажиллах удирдамжийг гарган ажиллаж эхлээд байна. Удирдамжинд 24 аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулахаар тусгасан бөгөөд 2018 оны 3 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн 2018 оны 3 дугаар сарын 22-ны өдөр хүртэл 5 аж ахуйн нэгж, байгууллагын/Ус-Ду ОНӨААТҮГ, ХХААГ, Боржигон чуулга, Номын сан, Музей/ 62 иргэнд мэдээлэл хийж, зөвлөмж зөвлөгөө өгч ажиллаад байна.






Үүнээс гадна иргэд олон нийтэд хүргэж буй үйлчилгээг илүү ойртуулж, сайжруулах, түргэн шуурхай болгох үүднээс аймгийн Улсын бүртгэлийн хэлтэстэй “Хамтран ажиллах гэрээ”-г байгуулан сумдад хамтарч “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг зохион байгуулж ажиллах болон бусад мэдээ мэдээллийг хоорондоо солилцон ажиллахаар гэрээ байгуулан ажиллаж байна.



Шивээговь сумын газар зохион байгуулалтын 2018 оны төлөвлөгөө батлагдсантай холбогдуулан газар өмчлүүлэх зарыг орон нутгийн “Залуус” телевизэд өгч зарлуулахаас гадна, байгууллагын Govisumber.gazar.gov.mn сайт, байгууллагын мэдээллийн самбар зэргээр зарлан 2018 оны 03 дугаар сарын 19-ны өдрөөс эхлэн

иргэдээс өргөдлийг хүлээн авч ажилласан. Нийт 2 байршилд 250 иргэнээс өргөдөл хүлээн авлаа.



Орлого төвлөрүүлэлт:

2018 оны газрын төлбөрийн орлого 132 сая төгрөгөөр батлагдсан бөгөөд 2018 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар 43,8 сая төгрөгийн орлогыг орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлээд байна.

Барилга, хот байгуулалт, оронсууц, нийтийнажахуй, барилгын материалын чиглэлээр:

Газрын харилцаа болон барилга, хот байгуулалтын чиглэлээр 6 албан байгууллагад мэдээллийн цаг хийж ажиллаж байна.

Хот байгуулалтын чиглэлээр:

- ГСА-н Сүмбэр сум, 220/110/35кВ-ын “Чойр” дэд станцын 35Кв-ын ИХБ-ийн өргөтгөл
- “И Эс Би Солар Энержи”ХХКомпанийн ГСА, Сүмбэр сум, 10МВт-ын “Сүмбэр” нарны цахилгаан станцын иж бүрдэл инвертерийн байгууламж зэрэг зургийг хянаж баталгаажуулсан.
- Сүмбэр сум, 3-р баг, Усан спортын сургалтын төвийн халаалтын ажлын төсвийн тооцоог гарган ашиглагч байгууллагад гарган өгсөн. /33,0 сая төгрөг/
- Сүмбэр сумын 3-р баг, 49 айлын хаус хорооллын ажлын зургийн гүйцэтгэгч “Хос мөнх шилтгээн”ХХКомпанийн зургийг хянаж санал хүргүүлсэн.
- Сүмбэр сум, 3-р баг, Цэргийн алдар хөшөөний тохижилтын ажлын техникийн тодорхойлолтын ХОХБТХэлтэстэй хамтран боловсруулсан.

Мэдээ тайлан:

- БХТөвд “Барилгын мэдээлэл” сэтгүүл захиалгыг орон нутгийн салбарын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгууллагуудаас судалгаа авч хүргүүлсэн.
- Аймгийн Аудитийн газарт хөрөнгө оруулалтын ажлын судалгаагарган хүргүүлсэн.


- БХТөвдбарилга байгууламжийн ашиглалтад орсон мэдээ, орон сууцны үнийн мэдээг гарган хүргүүлсэн.

Барилга байгууламжид үзлэг хийж дараах ажилд “Захиалагчийн барилгын техникийн хяналтын нэгдсэн дүгнэлт гаргах” ажилд ажилласан:

2018.03.14-ний өдөр Сүмбэр сумын “Нэгдсэн эмнэлгийн барилгын засвар”-ын ажил

Захиалагчийн хяналтын ажил:

- Сүмбэр сумын нэгдсэн эмнэлгийн барилгын засварын ажлыг “Эс Жи Эм” ХХКомпани 59,3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй гүйцэтгэж байна. Ажил 2018.01.19-нд эхлэж 2018.03.22-ний байдлаар комисс ажиллуулах шатандаа байна.
- Найрамдал хотхоны 8,15 дугаар байрны гадна дулаалга фасад засварын ажлыг “Гурван дэлгэр” ХХКомпани 160,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй гүйцэтгэж байна.



ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР